

Улирлын урьдчилсан төлөв

НЭГ. ТАНЫ АНХААРАЛД

Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Цаг Агаар, Орчны Тоон Загварчлал Судалгааны Хэлтэс (ЦАОТЗСХ)-ээс 2025 оны 8 дугаар сараас 10 дугаар саруудын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна.

Урьдчилсан төлөвийг [Цаг агаар \(weather.gov.mn\)](http://weather.gov.mn) цахим хуудсанд сар бүрийн 28-нд шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу.

Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-аас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11–326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ЦАОТЗСХ-ээс тодруулах боломжтой.

ХОЁР. УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

2.1 8–10 дугаар саруудын уур амьсгал

Агаарын дундаж температурын ОЖД нь наймдугаар сард Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 8...12°C, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь, говийн аймгуудын нутгаар 20...26°C, бусад нутгаар 12...20°C, есдүгээр сард Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 2...8°C, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь, говийн аймгуудын нутгаар 12...18°C, бусад нутгаар 8...12°C дулаан, аравдугаар сард Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 0...-8°C хүйтэн, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь, говийн аймгуудын нутгаар 6...10°C, бусад нутгаар 0...6°C дулаан байдаг.


Хур тунадасны ОЖД нь наймдугаар сард Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 60–100 мм, Алтайн өвөр говь болон говийн аймгуудын нутгаар 10–20 мм, бусад нутгаар 20–60 мм, есдүгээр сард Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 25–40 мм, Алтайн өвөр говь болон говийн аймгуудын нутгаар 0–10 мм, бусад нутгаар 10–25 мм, аравдугаар сард Хэнтийн уулархаг нутгаар 12–18 мм, Алтайн уулархаг нутаг болон говь, тал хээрийн бүс нутгаар 0–6 мм, бусад нутгаар 6–12 мм байдаг.

ГУРАВ. УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

3.1 2025 оны 8 дугаар сараас 10 дугаар саруудын цаг агаарын урьдчилсан төлөв


Наймдугаар сард. Сарын дундаж агаарын температурын ОЖД нь Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Ховдын төв, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төвийн зүүн хойд хэсгээр 8...12°C, Увс, Говь–Алтай, Баянхонгор,

Өвөрхангай, Дундговь, Дорнодын өмнөд, Ховдын зүүн хойд, Завханы баруун хэсэг болон Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар 20...26°C, бусад нутгаар 12...20°C дулаан байдаг (**Зураг 1а**).



Зураг 1а. 8 дугаар сарын агаарын дундаж температурын ОЖД (1991-2020)


2025 оны 8 дугаар сарын агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас дулаан байх төлөвтэй байна (**Зураг 1б**).



Зураг 16. 2025 оны 8 дугаар сарын агаарын дундаж температурын урьдчилсан төлөв (°C)


[Д-агаарын температур ОЖД-аас дулаан]

Сарын нийлбэр хур тунадасны ОЖД нь Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 60–100 мм, Алтайн өвөр говь болон говийн аймгуудын нутгаар 10–20 мм, бусад нутгаар 20–60 мм байдаг (**Зураг 2а**).



Зураг 2а. 8 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)

2025 оны 8 дугаар сарын нийлбэр хур тунадас Өмнөговь, Дорноговийн ихэнх хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (Зураг 2б).




Зураг 26. 2025 оны 8 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[Н-хур тунадас ОЖД-ийн орчим,


И-хур тунадас ОЖД-аас ахиу]

Есдүгээр сард. Сарын дундаж агаарын температурын ОЖД нь Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Өвөрхангайн баруун хойд, Төвийн зүүн хойд хэсгээр 2...8°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр 12...18°C, бусад нутгаар 8...12°C дулаан байдаг (Зураг 3а).



Зураг 3а. 9 дүгээр сарын агаарын дундаж температурын ОЖД (1991-2020)

2025 оны 9 дүгээр сарын агаарын дундаж температур Баян–Өлгий, Увс, Завханы нутаг, Ховд, Говь–Алтайн хойд, Архангайн баруун, Баянхонгорын баруун хойд хэсгээр ОЖД–ийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байх төлөвтэй байна (Зураг 3б).




Зураг 3б. 2025 оны 9 дүгээр сарын агаарын дундаж температурын урьдчилсан төлөв (°C)

[Н-агаарын температур ОЖД-ын орчим


Д-агаарын температур ОЖД-аас дулаан]

Сарын нийлбэр хур тунадасны ОЖД нь Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгийн ихэнх нутаг, Төвийн зүүн хойд, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр 25–40 мм, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговийн нутаг, Өвөрхангайн өмнөд хэсгээр 0–10 мм, бусад нутгаар 10–25 мм хур байдаг (**Зураг 4а**).



Зураг 4а. 9 дүгээр сарын хур тунадасны ОЖД (1991-2020)

2025 оны 9 дүгээр сарын нийлбэр хур тунадас Баян–Өлгий, Увс, Завханы нутаг, Ховд, Говь–Алтайн хойд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 4б**).




Зураг 46. 2025 оны 9 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[Н–хур тунадас ОЖД–ийн орчим


И–хур тунадас ОЖД–аас ахиу]

Аравдугаар сард. Сарын дундаж агаарын температурын ОЖД нь Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх, Увс, Архангайн баруун, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Өвөрхангайн баруун хойд, Төвийн зүүн хойд хэсгээр 0...-8°C хүйтэн, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутаг, Дорнодын зүүн өмнөд хэсгээр 12...18°C, бусад нутгаар 8...12°C дулаан байдаг (Зураг 5а).



Зураг 5а. 10 дугаар сарын агаарын дундаж температурын ОЖД (1991-2020)

2025 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур Увс, Завханы нутаг, Ховдын хойд, Архангайн баруун, Баянхонгорын баруун хойд хэсгээр ОЖД–аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 5б**).




Зураг 56. 2025 оны 10 дугаар сарын агаарын дундаж температурын урьдчилсан төлөв (°C)

[Н–агаарын температур ОЖД–ын орчим,


Х–агаарын температур ОЖД–аас хүйтэн]

Сарын нийлбэр хур тунадасны ОЖД нь Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгийн ихэнх нутаг, Төвийн зүүн хойд, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр 25–40 мм, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговийн нутаг, Өвөрхангайн өмнөд хэсгээр 0–10 мм, бусад нутгаар 10–25 мм хур байдаг (**Зураг 6а**).



Зураг ба. 10 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)

2025 оны 10 дугаар сарын нийлбэр хур тунадас Өмнөговь, Дорноговийн ихэнх, Дундговийн өмнөд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 6б**).



Зураг 6б. 2025 оны 10 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[Н–хур тунадас ОЖД–ийн орчим,

И–хур тунадас ОЖД–аас ахиу]

3.2 Зөвлөмж

Наймдугаар сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас дулаан, хур тунадас нутгийн өмнөд хэсгээр ахиу байх хэдий ч уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэнэтийн ус ихтэй аадар борооны давтагдал нэмэгдэж байгаа тул нийт нутгаар болзошгүй үер усны аюулаас сэрэмжтэй байхыг анхааруулж байна.

Цаашдаа 9 дүгээр сард агаарын дундаж температур нутгийн баруун хэсгээр ОЖД–ийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байх бол хур тунадас баруун аймгуудын нутгаар дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Харин 10 дугаар сард баруун аймгуудын нутгаар дунджаас сэрүүн, хур тунадас нутгийн өмнөд хэсгээр ахиу, бусад хугацаанд болон бусад нутгийн дунджийн орчим байх төлөвтэй байна.